

**“НАЙРАМДЛЫН ЭРДЭНЭС” ХҮҮХДИЙН ЗУСЛАНГИЙН  
ЭРГЭЛТЭЭР ИРЭХ БОЛОН ЗАРАХЫГ ХОРИГЛОСОН  
ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ**

Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Сэлэнгэ амралтын баазын “Найрамдлын эрдэнэс” хүүхдийн зуслангийн амрагч хүүхдүүдийн эргэлтээр ирэх хүнсний хориглосон бүтээгдэхүүний ЭМС-ийн 2013 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 207 дугаар тушаалын дагуу хавсралтад заагдсан доорх хүнсний бүтээгдэхүүнийг зарж худалдаалах болон эргэлтээр оруулахыг хориглоно.

1. Чихэр, мөхөөлдөс, шоколад зэрэг энгийн нүүрс ус ихтэй хүнсний бүтээгдэхүүн
2. Нийлэг буюу химийн аргаар авсан кремтэй бүтээгдэхүүн
3. Бүх төрлийн цуужуулсан, утсан, лаазалсан, бүтээгдэхүүн /давсалсан самар, цуу, загас, хиам, махан бүтээгдэхүүн, зайдас г.м/
4. Өндөг , хуурай өндөг, майонез
5. Байгалийн бус өтгөрүүлсэн сироп ашиглаж үйлдвэрлэсэн бүх төрлийн шүүс
6. Бүх төрлийн хийжүүлсэн ундаа
7. Кофе
8. Их тосонд шарсан бүтээгдэхүүн, хоол хүнс /шарсан төмс, шаржигнуур тахиа г.м/
9. Түргэн хоол /Пицца, бургер, хотдог г.м/
10. Төрөл бүрийн нийлэг буюу химийн аргаар гарган авсан хоол амтлагч /вигор, дошида/
11. Шөлний тос, өөхөн тос, болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн /гэрийн хайрсан боорцог, мушгиа боов г.м/
12. Хайлуулсан элсэн чихэрт дүрж амталсан гурилан бүтээгдэхүүн /дулааны боловсруултад орсноос хойш тасалгааны хэмд 3 цаг буюу түүнээс дээш хугацаанд хадгалсан болон хоносон хоол, хүнсний бүтээгдэхүүн/
13. Холбогдох хяналтын байгууллагаас эрсдэлийн үнэлгээ хийлгүүлээгүй хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний бүтээгдэхүүн, биологи /ариутгагч бодис, шавж устгалын бодис г.м/-р бохирдсон хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдээр бэлтгэсэн хоол хүнс
14. Технологийн горим мөрдөөгүй хийгдсэн /дулааны боловсруулалтад дутуу оруулсан, боловсруулалтын хугацаа алдсан г.м/ хоол хүнс
15. Төрөл бүрийн гүн болон хагас хөлдөөсөн бүтээгдэхүүн
16. Дагалдах бичиг баримт бичиггүй /шинжилгээний бичиг, гарал үүслийн бичиг, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдээр бэлтгэгдсэн хоол хүнс.

**ТАНИЛЦАЖ, ӨӨРИЙН ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛЖ ХҮҮХЭД  
ХАМГААЛЛЫН БОДЛОГОД НЭГДСЭН ЭЦЭГ, ЭХ, АСРАН ХАЛАМЖЛАГЧ ТАНД  
БАЯРЛАЛАА**